



ЦАГААН ИДЭЭ



Сүүгээр цагаан идээ хийдэг. Цагаан идээнд сүү, тараг, айраг, ааруул, эээзгий, бяслаг, өрөм, аарц зэрэг зүйл орно. Цагаан идээ хүний биед маш сайн. Гүүний сүүгээр айраг исгэнэ. Хонь ямааны сүүгээр цай сүлнэ, тараг бүрж ааруул хийдэг. Ааруул нь шүдний бат бэх чанарыг сайжруулдаг.





МӨӨГ

Манай оронд олон төрлийн мөөг ургадаг. Мөөгийг хортой мөөг, хоргүй мөөг гэж ангилдаг. Мөөгийг хоол хүнсэнд хэрэглэнэ. Бас эмийн ургамал болгон ашигладаг. Цагаан мөөг уулын энгэр, тал газар мөөгний хүрээнд ургана. Бороо орсны дараа мөөг сайн ургадаг. Мөөгийг түүхдээ ишний угаар нь огтлон авдаг.





УСНЫ ШУВУУ



Усны шувууд хавар халуун орноос нисэн ирдэг. Усны шувууд гангар гунгар дуугаран нуурын хөвөөнд хөвдөг. Шувууд ганганалдан гунганалдан дуугарах нь сайхан сонсогдов. Голын усанд галуу, ангир, нугас, хун гээд сайхан шувууд хөвнө. Хавар болохоор гол мөрөн нуурын ус хайлдаг. Галуу шувууд ганганан дуугарах үнэхээр сайхан сонсогдов.





ТАЛ ХЭЭР



Монгол хүмүүс бид тал хээр нутагт таван хошуу малаа малладаг. Монгол гэрийн талаар сонирхолтой баримтууд олон байдаг. Гадаадын орнуудад манай улсын монгол гэрийн талаар хийсэн судалгаанууд маш олон байдаг. Монгол хүмүүс, хүүхдүүд бид тал хээр нутагт төрсөндөө бахархах хэрэгтэй.





ГОЛ



Манай нутаг гол мөрөн ихтэй.
Манайх Орхон голоос усаа авдаг.
Гол усаа хайрлан хамгаалах нь
хүний үүрэг мөн. Хавар гол мөрөн
урсан хайлдаг. Өвөл гол мөрөн
хөлддөг. Би ах нартайгаа мөсөн
дээр гулгах дуртай. Дулаан
улиралд бид голд усанд ордог. Гол
усаа бохирдуулалгүй хайрлан
хамгаалах хэрэгтэй.





ДӨРВӨН УЛИРАЛ



Манай орон жилийн дөрвөн улиралтай энх мөнхийн сайхан орон. Манай дүү хаврын улиралд илүү дуртай. Өвөл их хүйтэн, хавар салхи шуурга ихтэй, намрын улиралд сэрүүн байдаг. Манай аав өвлийн улиралд дуртай. Харин манай ээж хаврын улиралд дуртай. Манай оронд дөрвөн улирал ээлжлэн солигддог билээ.





ШУВУУД



Манай оронд олон төрлийн шувууд байдаг. Хон хэрээ гуаг гуаг, гуаг гуаг хэмээн дуугардаг. Хөхөө шувуу гүүг гүүг, гүүг гүүг хэмээн дуугардаг. Гааг гааг, гааг гааг дуугараад галуу усанд шумбадаг. Урин хавар ирэхэд усны шувууд халуун орноос нисэн ирдэг. Нуурын усанд ангир, галуу, нугас, хун гээд олон төрлийн сайхан шувууд хөвдөг.





ЦАГ АГААР

Манай монгол улс цаг агаарын хуурай сэрүүн уур амьсгалтай. Өнөөдрийн мэдээгээр ойрын өдрүүдэд хүйтэн салхитай байхыг анхаарууллаа. Дараагийн долоо хоногоос ширүүн бороо орно хэмээн цаг агаарын мэдээнээс сонслоо. Тунгалаг цаг агаарын мэдээг сонсон ангийнхандаа хэлэв. Багш бидэнд цаг агаарын мэдээг танилцуулав.





МАЗААЛАЙ



Нэгэн өдөр хичээл дээр багш бидэнд ховордсон ан амьтдын талаар хэлж өглөө. Манай улсад нэн ховордоод байгаа амьтдын нэг бол говийн мазаалай баавгай билээ. Гэвч ойрын жилүүдэд хулгайн анчид ихэссэн учраас мазаалай баавгай маань ховордсон. Тиймээс хүүхдүүд ээ! ховордсон амьтдыг хайрлан хамгаалаарай.





ТУУЛАЙ



Монгол оронд боролзон, түвд, чандаган, молтогчин туулай байдаг. Боролзон туулай ой хээрийн бүсээр нутагладаг. Молтогчин туулайнууд газар ухаж үүр засдаг. Молтогчин туулай төрснөөс хойш 2 долоо хоноод нүдээ нээдэг. Молтогчин бөжингүүдээ хэвтэж байгаад хөхүүлнэ. Харин боролзон туулай шиг сайхан сэтгэл гарган бусдын бөжинг хөхүүлэхгүй.





ААЛЗ

Аалзанд л ганцхан заяасан маш олон чадвар бий. Тухайлбал шоргоолж шиг төрхтэй зуу гаруй төрлийн аалз байдаг. Тэдгээр нь шоргоолж шиг төрхөө ашиглан идэш хоолоо амархан олж чаддаг овжин амьтад ажээ. Түүнчлэн загас, шувуу, гүрвэл барьж иддэг ч аалз бий. Дэлхий дээрх бүх аалз арьсаа гуужуулж шинээр нөхөн төлжүүлэх чадвартай байдаг.





ХАЛИМ



Хөхтөн амьтдын **адил халим** нь **уушгиар агаар** авч **хүчилтөрөгчөөр** амьсгалдаг. **Бүлээн цустай**, үр зулзагаа **хөхүүлж сүүгээр** тэжээдэг байна. **Сэлүүр** нь завины **сэлүүр** мэт хавтгай ба сүүл нь **загасных шиг хөндлөн** биш. **Арьсан дороо зузаан** өөхөн **давхаргатай** ба энэ нь **энерги хадгалж хуримтлуулах, биеийн дулааныг хадгалах үүрэгтэй**.





ЯНГИР



Янгир бол **ууланд амьдардаг** **зэрлэг ямаа билээ**. **Төлийг** нь **ишиг гэнэ**. **Ишиг** нь их **сэргэлэн цовоо хөөрхөн амьтан**. **Янгир** уул **хадаар дамжин дүүлэн дүүлэн явдаг**. **Янгир хаврын улиралд яргуй иддэг**. **Яргуй хамгийн эрт ургадаг**. **Хүүхдүүд ээ! Ан амьтад, уул ус, ургамал ногоогоо хайрлацгаая**





ХОНЬ



Монгол орон хонин сүргээр баян. Хонь нь эрт дээр цагаас гэрийн тэжээмэл мал болжээ. Хундан цагаан хонь минь ашиг шим ихтэй. Хонины ноос, арьс шир, мах сүүг нь ашигладаг. Сүү нь тослог ихтэй байдаг. Хонины төлийг хурга, эцэг малыг хуц, эх малыг эм хонь гэдэг.





ХУС

Манай орны ойд хус элбэг ургадаг. Хус навчлах нь хаврын урин цаг болж буйг илтгэнэ. Хусыг бусад модноос ялгаж танихад амархан. Хус цагаан холтостой, хурц ногоон навчтай байдаг. Хусны холтсоор үйсэн сав хийнэ. Хусны нахиагаар бас эм хийдэг. Хус мод дунджаар 80 - 100 жил насалдаг байна.

